



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 07 өдөр


Дугаар А/361


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Тулгар төрийн 2229, Их Монгол улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын нээлт, хаалтын үйл ажиллагаа, Үндэсний бөхийн барилдаан, Хурдан морины уралдаан, Үндэсний сурын харвааг дамжуулах зардалд 4 000 000 төгрөг /дөрвөн сая/-ийг хавсралтаар баталж, зарцуулсугай.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 4 000 000 төгрөг /дөрвөн сая/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны батлагдсан төвийн 5.35-д тусгагдсан "Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр"-өөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 07-ны өдрийн
А/361 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН БАЯР НААДМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАМЖУУЛАЛТ,
МЭДЭЭЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ
/ТӨГРӨГӨӨР/

Д/д	Хэвлэл мэдээллийн байгууллагын нэр	Үйл ажиллагаа	Төсөвт өртөг
1.	Олон ястны телевиз	Засаг даргын мэндчилгээ, Баяр наадмын концерт, Наадмын үйл ажиллагааны нээлт, Бөхийн барилдааныг шууд дамжуулах	1.000.000
2.	Ховд телевиз	Засаг даргын мэндчилгээ, Баяр наадмын концерт, Наадмын үйл ажиллагаа, Морины уралдааныг дамжуулах	1.000.000
3.	Жаргалант телевиз	Засаг даргын мэндчилгээ, Баяр наадмын концерт, Наадмын үйл ажиллагаа, Сурын харваа дамжуулах	500.000
4.	Ховдын мэдээ сонин, Ховдын толь сонин, Ховд ньус цахим сайт-TV9, Монголын радиод мэдээ дамжуулах	Засаг даргын мэндчилгээ, Наадмын үйл ажиллагааг сурвалжилж нийтлэх	900.000
5.	Нью Ховд, Ховд таймс	Засаг даргын мэндчилгээ, Наадмын хөтөлбөр нийтлэх	200.000
6.	Засаг даргын мэндчилгээ бэлтгэх зардал	Бэлтгэл ажил	400.000
Нийт дүн			4.000.000

-оОо-